

Гэрээний эрх зүйн хөгжлийн нийтлэг чиг хандлага

Common Trends in Contract Law Development

Түмэнжаргалын Мэндсайхан

Хууль зүйн ухааны доктор (Ph.D.).


Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн

Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор

Улаанбаатар хот, Монгол Улс

mendsaikhan@num.edu.mn

© T.Mendsaikhan, 2026



[Attribution-NonCommercial 4.0 International](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)
(CC BY-NC 4.0)

[Товч утга]

Сүүлийн жилүүдэд өрнөсөн технологийн хувьсгал, нийгмийн үнэлэмжийн өөрчлөлт, арилжааны практикийн хандлага, олон улсын сайн туршлага, бусад улсын хууль тогтоомжийн өөрчлөлтийг харгалзан үзэх замаар үндэсний хууль тогтоомж, гэр дундаа гэрээний эрх зүйн зохицуулалтаа шинэтгэх арга хэмжээг тогтмол авах шаардлага тулгарч байна. Гэрээний урьдчилан төсөөлөгдөх байдал, сул талыг хамгаалах шаардлага, гэрээний хариуцлагын үр нөлөөтэй арга, үндсэн эрхийн нөлөөлөл, мөн эх сурвалж сонголтын талаарх эрх зүйн шинэ сэтгэлгээ нь олон улс орны хууль тогтоомжийн шинэтгэл болон шүүх, арбитрын практикт дорвитой нөлөө үзүүлэх болов. Түүнчлэн хил дамнасан гэрээний харилцаа өргөжиж, олон улсын шинжтэй гэрээнд хууль сонгох, шүүхийн харьяалал тогтоох журам, дижитал гэрээний өргөжилт нь олон улсын түвшинд анхаарал татсан хэвээр байна. Ийм нөхцөлд гэрээний эрх зүйн хөгжлийн нийтлэг хандлагыг тодорхойлж, Монгол Улсын гэрээний эрх зүйн зохицуулалт болон шүүхийн практикт чиглүүлэгч зарчмуудын үр нөлөөг нэмэгдүүлэх, дижитал орчинд нийцсэн гэрээний шинэ дүрс, хамтын хариуцлагыг хүлээн зөвшөөрөх, олон улсын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор энэхүү өгүүллийг бичив.

[Түлхүүр үг]

Орчин үеийн гэрээний эрх зүй, Гэрээний урьдчилан төсөөлөгдөх байдал, Гэрээний сул тал, Хуулиар тогтоосон хүү, Хүний суурь эрх, Хэрэглэгдэх хуулийн сонголт, Арбитрын хэлэлцээр, Шүүхийг сонгох, Зөөлөн хууль, Дижитал гэрээ.

I. Удиртгал

Улс орнууд нийгэм, улс төр, эдийн засгийн орчны өөрчлөлт, технологийн дэвшилийг харгалзан эрх зүйн шинэтгэл хийж, бизнес эрхлэх орчноо тааламжтай, өрсөлдөхүйц болгохыг зорьж байна. Франц улс 1804 оны Иргэний хуулийн гэрээний эрх зүйд хамаарах хэсэгт томоохон өөрчлөлтийг 2016-2018 онд оруулав¹. БНХАУ иргэний хууль, тэр дундаа гэрээний эрх зүйн зохицуулалтаа шинэчлэх ажлыг олон жил судалж явуулсны² үр дүнд 7 ном, 1260 зүйл бүхий шинэ Иргэний хуулиа батлаж, 2021 оноос даган мөрдөж байна. Монгол Улсын 2002 оны Иргэний хуульд ч олон улсын жишигт нийцсэн эрх зүйн хэм хэмжээний бүтээц цөөнгүй. Гэвч сүүлийн 20 гаруй жилд өрнөсөн технологийн хувьсгал, нийгмийн үнэлэмжийн өөрчлөлт, арилжааны практикийн хандлага, олон улсын сайн туршлага, бусад улсын хууль тогтоомжийн өөрчлөлтийг харгалзан үзэх замаар үндэсний хууль тогтоомж, тэр дундаа гэрээний эрх зүйн зохицуулалтаа шинэтгэх арга хэмжээг тогтмол авах шаардлага тулгарч байна.

Орчин үед улс орнуудын судлаачдын хамтын ажиллагаа, харилцан мэдээлэл солилцоо, эрх зүйн харьцуулсан судлал эрчимтэй өргөжиж байна. Энэ нь улс орнуудын эрх зүй, тэр дундаа гэрээний эрх зүйн хууль тогтоомжийн зохицуулалт харилцан уусах, ижил үзэл баримтлалд үндэслэх явдал аажмаар өргөжих гол хүчин зүйл болно. Өнөөдөр дэлхийн хэмжээнд нийтлэг нэгдмэл эрх зүйн орчин бүрдүүлэх хамгийн боломжтой эрх зүйн салбар бол гэрээний эрх зүй юм. Ийм учраас гэрээний эрх зүйн зохицуулалтыг ижилтгэх, нэгдмэл эх сурвалж бүтээх оролдлого, олон улсын хамтын ажиллагаа зохих үр дүн өгч эхэлжээ. Тухайлбал, Олон улсын бараа худалдах-худалдан авах гэрээний тухай 1980 оны Венийн конвенц³, ЮНИДРОУ-ын 2016 оны Олон улсын арилжааны гэрээний зарчмууд гэдэг баримт бичгийг нэрлэж болно.

Судалгааны хүрээнд гадаадын зарим улсын иргэний хуулийн шинэтгэл, гэрээний талаарх олон улсын конвенц, зөөлөн хуулийг харьцуулан судлахын зэрэгцээ манай улсын хууль хэрэглээний практикт тулгамдаж буй асуудлыг тодруулах оролдлого хийв. Энэхүү өгүүлэлд гэрээний эрх зүйд гарч буй шинэлэг үзэл баримтлал, хэм хэмжээний хөгжлийн нийтлэг чиг хандлагыг тодорхойлж, Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох зарим арга зам,

¹ Solene Rowan, *The New French Law of Contract*, (Oxford University Press, 2017), 1-2.

² Т.Дайчин, “БНХАУ-ын Иргэний хуулийн хөгжлийн үе шат (Иргэний хуулийн бичиг боловсруулалтын хүрээнд)”, Эрх зүй, 52 (2), 2016, 228-230 дахь тал.

³ Монгол Улс тус конвенцид 1997 онд нэгдэн орсон

хуульчид тэр дундаа шүүгч, арбитрчдын маргаан шийдвэрлэх, үндэслэл гаргах ажиллагаанд нэмэртэй гаргалгаа, үзэл хандлагыг санал болгоно.

II. Гэрээний эрх зүйн чиглүүлэгч зарчмууд, тэдгээрийн үр нөлөөний өсөлт

Өнөөдөр гэрээний эрх зүйн онолын орон зай харьцангуй нээлтэй, хэм хэмжээний зохицуулалтын тайлбар, үндэслэл хараахан бүрэн боловсруулагдаагүй гэж судлаачид үзэж байна⁴. Гэхдээ гэрээний эрх зүйн суурь зарчмууд нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Гэрээний эрх зүйн гурван гол чиглүүлэгч зарчим (guiding principles) гэдэгт 1/ гэрээний эрх чөлөө (freedom of contract), 2/ гэрээний шударга байдал (contract fairness), 3/ гэрээний урьдчилан төсөөлөх байдал (contractual certainty) хамаарна⁵. Үүнээс гадна гэрээний үүргийг зайлшгүй гүйцэтгэх зарчим (facta sunt servanda) чухал ач холбогдолтой. Эдгээр зарчим нь эрх чөлөө ба нийгмийн шударга ёсны тэнцвэрийг хангахад үйлчилж, хүмүүсийн хамтын ажиллагаа, эд хөрөнгийн солилцоо хэвийн явагдах үзэл баримтлалын чиглэмж болохын⁶ зэрэгцээ хуулийг тайлбарлан хэрэглэх үндэслэлийг өөртөө агуулж байдаг⁷.

A. Гэрээний урьдчилан төсөөлөх байдал ба зөрчлөөс хамгаалагдах эрх

Сүүлийн үед хуулийн тодорхой, урьдчилан төсөөлөх байдлыг бүрдүүлэхэд улс орнууд ихээхэн анхаарч байна. Эрх зүйн өөр өөр тогтолцоонд хуулийн тодорхой байдлыг янз бүрийн агуулгаар ойлгодог. Эх газрын эрх зүйн бүлийн улсуудад хуулийн заалтын агуулга тодорхой, нарийвчлал сайн, үйл баримтын олон янз байдалд хэрэглэх боломжтой байхаар төрөлжүүлсэн хуулийг батлан гаргадаг. Ийм учраас хуулийн тодорхой байдал (legal certainty) хуулийн эх бичвэрээс эхтэй гэж үздэг. Нөгөө талаар хуулийг хэрэглэх хүний ур чадвараас хамаарч хууль өөрөө тодорхой бус байдлыг үүсгэх эрсдэл дагуулна.

Харин английн эрх зүйд тодорхой байдлыг “хууль ёсны хүлээлт ба итгэлийг хамгаалах” (legitimate expectation and protection of trusts)

⁴ Pier Giuseppe Monateri (Ed.), *Comparative Contract Law*, (Edward Elgar Publishing, 2018), 17.

⁵ Hugh Beale, Bénédicte Fauvarque-Cosson, Jacobien Rutgers, Stefan Vogenauer, *Cases, Materials and Text on Contract Law*, 3rd Edition, (Hart Publishing, 2019), 8 дахь тал. Энд 3 зарчмыг дурдсан. Харин миний бие Гэрээний эрх зүй (2021, 13 дахь тал) номондоо сүүлийн 2 зарчмыг нэгтгэн “шударга ёс, харилцан итгэлцэлийн зарчим” гэж нэрлэсэн.

⁶ Т.Мөнхжаргал, *Иргэний эрх зүй: Ерөнхий анги*, (Улаанбаатар: 2003), 16 дахь тал.

⁷ Бат-Эрдэнийн Буянхшиг, *Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт*, (Улаанбаатар: 2021), 238 дахь тал.

зарчмын суурь гэж ойлгоно⁸. Англи хуульчдын хувьд хуулийн нийтлэг зохицуулалтаас илүү талуудын гэрээний эрх чөлөө, гэрээний үүргийг албадах боломж, тодорхой хэрэг, тохиолдол шийдвэрлэсэн шүүхийн жишгийг чухалчилж байдаг. Учир нь, хуулийн тодорхой байдлыг бус, гүйлгээ буюу арилжааны тодорхой байдал(transactional certainty)-ыг баталгаажуулах чухал гэж үздэг.

Гэрээний тодорхой буюу урьдчилан төсөөлөгдөх байдлын гол агуулга нь хэрэг маргааныг шийдвэрлэхдээ талуудын байгуулсан гэрээний нөхцлийг чанд баримтлах, өөрөөр хэлбэл (1) талуудын тохиролцоо, (2) аль нэг талын зүй ёсны хүлээлтийг хүндэтгэх шүүгчийн бүрэн эрхээр тодорхойлогдоно.

(1) Талуудын тохиролцоог хүндэтгэж, тэдний тохиролцсоны дагуу гэрээний зөрчлийн үр дагаврыг шийдвэрлэхэд маргаан таслагч буюу шүүгчийн зүгээс онцгой ач холбогдол өгөх ёстой. Энэ нь гэрээний эрх чөлөөний зарчмаар давхар хамгаалагдана. Хэрэв талуудын тохиролцоо тодорхой бус байвал төсөөлөгдөх нөхцөл байдал (implied conditions), тэр дундаа тухайн салбарын заншил, талуудын хооронд тогтсон ажил хэргийн харилцаа, бизнесийн шударга ёсыг баримтлах хандлага олон улсын түвшинд тогтсон байна. Үүнийг олон улсын гэрээ конвенц, баримт бичиг (1980 оны CISG, 2016 оны PICC) төдийгүй үндэсний хууль тогтоомж(жишээ нь, Японы Иргэний кодексын 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (шударга ёс), ХБНГУ-ын Иргэний кодексын 157 дугаар зүйл(Гэрээг тайлбарлах))-оос харж болно. Монгол Улсын 2002 оны Иргэний хуулийн 4.2-т “... зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ”-нд нийцүүлэх, 198.6-д “...талуудын хооронд тогтсон практик, ажил хэргийн хүрээнд тогтсон заншил” зэрэг нөхцөл байдлыг харгалзан гэрээг тайлбарлахаар заасан байдаг. Харамсалтай нь, манай хууль зүй болон шүүхийн практикт “талуудын илэрхий ба далд тохиролцоо”-г хүндэтгэх бус, хуулийн зохицуулалтаар хашиж маргаан шийдвэрлэх хандлага давамгайлсан хэвээр байна. Энэхүү хуучинсаг байдал нь олон улсын нийтлэг хандлагатай хөл нийлүүлэхгүй бөгөөд бизнес, арилжааны зүй ёсны хөгжилд саад болж байна.

(2) Гэрээний нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй буюу хугацаа хожимдуулсан, доголдолтой үүрэг гүйцэтгэсэн зэрэг зөрчлийн улмаас гэрээний нөгөө тал гэрээнээс татгалзсан эсхүл гэрээг цуцалсан тохиолдолд зөрчил гаргасан үүрэг гүйцэтгэгч талд ямар хариуцлага хүлээлгэх үү, үүрэг гүйцэтгүүлэгч тал ямар эрхтэй байх уу, ямар төрлийн хохирлыг хэрхэн шаардах боломжтой байх вэгэдэг асуултад хариулахын тулд “гэрээний тодорхой

⁸ Английн эрх зүйн ном зохиолд “legitimate expectation” гэх үзэл хандагыг анх хүлээн зөвшөөрсөн *Robinson v Harman* (1848) кейсыг олонтоо эш татсан байдаг.

буюу урьдчилан төсөөлөгдөх байдал” зарчмыг гол үндэслэл болгож байна. Энд “тодорхой” (certainty), “зүй ёсны хүлээлт” (reasonable expectation), “урьдчилан төсөөлөгдөх байдал” (foreseeability) гэх мэт нэр томъёог түгээмэл ашиглаж байгаа бөгөөд эдгээр нь ихэвчлэн “итгэлцлэл”-ийг хамгаалж улмаар гэрээний шударга ёсыг тогтооход илүүтэй чиглэнэ. Итгэлцлэлийг хамгаалах үндэслэлийн тухай шүүгч агсан Ж.Оюунтунгалаг “Гэрээний үүргийг бодитой биелүүлнэ гэж талууд харилцан итгэсний үндсэн дээр урьдчилан тохиролцдог. Гэвч ирээдүйд уг гэрээ биелэгдэхгүй буюу үүргийн зөрчил гарвал үр дагаврыг хэрхэн шийдвэрлэхээ нэг бүрчлэн тохиролцоогүй байх нь түгээмэл. Учир нь, гэрээний харилцаанд орж буй хүмүүс нөгөө талаа үүргээ биелүүлнэ, зөрчил гаргахгүй гэсэн итгэлтэй байгаа тохиолдолд гэрээ байгуулна. Хэрэв итгэлгүй бол тэдгээрийн хооронд гэрээ байгуулагдахгүй байх байсан. Өөрөөр хэлбэл, гэрээ нь итгэлцэл дээр үндэслэгдэн байгуулагддаг” гэж тэмдэглэсэн байдаг⁹. Ийм учраас гэрээ байгуулах үед талууд гэрээний ирээдүйг хэрхэн төсөөлж байсан, тухайлбал, гэрээний явцад нөлөөлөх хүчин зүйл, эрсдэл, хэрэв гэрээ зохих ёсоор биелэгдвэл талуудад ямар боломж, давуу тал, орлого, ашиг бий болох байсан, харин гэрээ зөрчигдвөл ямар боломжоо алдах, ямар хохирол учрах байсныг тодруулсны үндсэн дээр гэрээний зөрчлийн үр дагавар, тэр дундаа хохирлын төрөл, хэмжээг тогтоох нь ухаалаг бөгөөд зүй ёсны болно. Энэ нь нэг талаас гэрээний үүрэг гүйцэтгүүлэгч талын бодитой, боломжтой, зүй ёсны хүлээлт, нөгөө талаас үүрэг хүлээгч талын зөрчлийн үр дагаврыг мэдэх, төсөөлөх боломжтой хэр хэмжээн, мөн талуудын тохиролцоо, хамтын ажиллагаа биелэх бодит боломж, үүсэх эрсдэлийг харгалзан үзсэн шийдэл юм. Монгол Улсын Иргэний хуулийн 227.3-т хоёр талт гэрээ зөрчигдсөн тохиолдолд зөрчсөн тал нөгөө талын “...зайлшгүй орох байсан орлого”-ыг хохиролд тооцон олгохоор зохицуулсан ба үүгээр нотолгооны өндөр шалгуурыг тогтоожээ. Гэвч олон улсын түвшинд “гэрээний тодорхой байдал буюу итгэлцэлийг хамгаалах” зарчмын дагуу хохирогчийн зүй ёсны хүлээлтийн хүрээнд олох байсан орлогыг тооцож гаргуулах хандлага тогтсон байна. Учир нь, нэгэнт биелэгдээгүй гэрээний хувьд “зайлшгүй орох” гэдгийг тогтоох бодит боломжгүй,

Дүгнэлт. Манай улсын хувьд гэрээний талуудын бие даасан, чөлөөт байдлыг хүндэтгэх, төсөөлөгдөх нөхцөл буюу заншлын хэм хэмжээг хэрэглэхээс илүүтэй хуулийн зохицуулалтыг чухалчлах хандлага шүүхийн практикт хэвээр байна. Иргэний хуульд заавал дагаж мөрдөх эсхүл талууд өөрөөр тохирч болох хэм хэмжээний

⁹ Жаргалсайханы Оюунтунгалаг, Иргэний эрх зүй: Гэрээний үүрэг, (Улаанбаатар: 2022), 43 дахь тал.

шинжийг ялгамжтай байдлаар бичээгүй, хэм хэмжээг хэрэглэх тайлбар, тодруулга бүхий хэм хэмжээ ховор тусгагдсан зэрэг шалтгаанаар хуулийн тодорхой байдал, улмаар гэрээний урьдчилан төсөөлөгдөх байдал бүрэн хангагдахгүй байна. Үүнд хууль зүйн арга техник төлөвшөөгүй¹⁰, хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоогүй явдал¹¹ ихээхэн сөрөг нөлөө үзүүлжээ.

Б. Гэрээний шударга байдал ба сул талыг хамгаалах шаардлага

Гэрээний шударга байдлыг хангах гэдэгт тэнцвэргүй байдал, үүнийг зохицуулах арга хэрэгслийг хамааруулна. Шударга ёс(good fair)-ыг хангах үүднээс төсөөлөгдөх нөхцөл(implied term)-ийг гэрээний зарим төрөл, тохиолдолд хэрэглэж болно. Ялангуяа гэрээний нэг тал нь сул тал (weaker party) байх үед ийм арга хэрэгслийг ашиглах зохистой. Гэхдээ гэрээний харилцаанд хуулийн тодорхой байдал талуудын тохиролцоогоор хамгийн сайн хангагдах бөгөөд тохиролцоо байхгүй үед заншлын хэм хэмжээ, хуулийн зохицуулалт, шүүхийн оролцоо бол нэмэлт арга хэрэгсэл болно.

Гэрээ байгуулах, гэрээний нөхцлийг тогтооход талуудын бодит оролцоо, нөлөөлөл, давамгайлах шинжийг харгалзан үзэж сул тал(weaker party)-ыг хамгаалах шаардлага зүй ёсоор үүснэ. Энэ нь нэг талаас гэрээний эрх чөлөөг хязгаарлаж, нөгөө талаас гэрээний шударга байдлыг тогтоох боломжийг олгоно.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалахаас гэрээний сул талыг хамгаалах ерөнхий арга руу шилжиж байна. Хэрэглэгчийн гэрээний асуудлыг өмнөх жилүүдэд хөндөж байсан бол сүүлийн үед хэлэлцээр хийх хүч чадалгүй, гэрээний нэг талын эрх ашгийг ихээхэн анхаарч зарим улс орон энэ чиглэлд хуулийн өөрчлөлт хийж эхэлжээ¹².

Эх газрын эрх зүйн улсуудад талуудын чөлөөт байдал буюу гэрээний эрх чөлөөг хязгаарлах олон үндэслэлийн нэг бол сул тал(хэрэглэгч, зарим бизнес эрхлэгч)-ийг хамгаалах явдал юм. Гэрээ байгуулахын өмнөх үүрэг, шударга бус нөхцлийн зохицуулалтууд хөгжиж байна. Гэрээний нэг тал давуу байдлаа ашиглаж шударга бус, зохисгүй нөхцөлөөр ашиг, өгөөжөө нэмэгдүүлэх үйлдэлд орчин үеийн гэрээний эрх зүй их анхаарах болжээ. Стандарт нөхцөл, гэрээг

¹⁰ Түмэнжаргалын Мэндсайхан, “Хууль зүйн техник ба холбоос үгийн хэрэглээ”, Хууль дээдлэх ёс, 76 (2), 2022.

¹¹ Түмэнжаргалын Мэндсайхан, “Орон сууцны талбайн маргаан бүхий иргэний хэрэг ба Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн хэрэглээ (Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ)”, Эрх зүй, 51 (1), 2019.

¹² Solene Rowan, *The New French Law of Contract*, (Oxford University Press, 2017), 7. Франц улс 1804 оны Иргэний кодексын гэрээний зохицуулалтад 2016-2018 онд томоохон шинэтгэл хийсэн.

тайлбарлах тусгайлсан арга, сайн санаа, шударга ёсны зарчим, гэрээ эсхүл гэрээний зарим шударга бус заалтыг хууль бусад тооцох зэрэг арга хэрэгслийг ашиглаж гэрээний эрх чөлөөг хязгаарлаж сул талыг хамгаалах боломжтой.

Стандарт нөхцөл бол 19 дүгээр зууны аж үйлдвэрийн хувьсгалыг дагалдаж үүссэн масс гэрээнүүдийг үр ашигтай, зардал багатайгаар шуурхай байгуулахад чиглэдэг¹³. Зах зээлд давамгайлах байр суурьтай үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч туршлагатай бизнесийн байгууллагууд стандарт нөхцлийг санал болгохдоо эрсдэлийг нөгөө талдаа шилжүүлсэн, эрх ашгийг нь илтэд хөндсөн зохисгүй нөхцлийг оруулах практик хүчтэй илрэх болсон. Ялангуяа хэрэглэгчийн хувьд гэрээний нөхцлийг унших, хэлэлцээр хийх цаг хугацаа болон санхүү нөөц байхгүй, бүтээгдэхүүн, үйлчилгээний нарийн утга, эрсдлийг үнэлэх мэргэжлийн туршлагагүй учраас тухайн нөхцлийг хянах бодит боломжгүй байдаг. Иймд зохисгүй стандарт нөхцлийг хуулиар эсхүл шүүхийн журмаар хүчингүйд тооцох асуудлыг 1970-иад оноос улс орнууд хуулиар зохицуулах болжээ. Европын Зөвлөлийн “Хэрэглэгчийн гэрээний шударга бус нөхцөл”-ийн талаарх 1993 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн Удирдамж нь компани ба хэрэглэгч хоорондын эрх мэдлийг буруугаар ашиглах явдлыг засах, хянах үзэл баримтлалд суурилсан байдаг.

Шударга бус нөхцлийг хязгаарлахад хэрэглэгчийн эрх хамгаалах сайн дурын болон захиргааны байгууллага, түүнчлэн шүүхийн хяналт чухал ач холбогдолтой. Жижиг болон дунд бизнес эрхлэгчид, стартап бизнесүүдийн хувьд нийтлэг ашиг сонирхлоо хамгаалах үүнээс өөрсдийн үйл ажиллагаанд холбоотой гэрээний стандарт нөхцлийг хянах, зохисгүй заалтыг өөрчлөх талаар хамтран ажиллавал үр дүнд хүрнэ. Ийнхүү хамтран ажиллах боломжийг хуулиар дэмжиж байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 200-202 дугаар зүйлүүдэд стандарт нөхцлийн зохицуулалтыг тусгаж, стандарт нөхцөл ойлгомжгүй бол санал хүлээн авагч талд ашигтайгаар тайлбарлахаар 201 дүгээр зүйлд, мөн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэггүй иргэнтэй байгуулсан гэрээний шударга бус, тэнцвэргүй зарим заалтыг хүчин төгөлдөр бус байхаар 202 дугаар зүйлийн 202.2 дахь хэсэгт тус зохицуулжээ. “Иргэний хуулийн 202 дугаар зүйлд тусгагдсан агуулгын хяналтын гол үзэл бодол нь гэрээний талууд харилцан итгэл үнэмшил, шударга ёс, нээлттэй байдлыг эрхэмлэн гэрээний стандарт нөхцлийг гэрээнд тусгахыг шаарддаг” гэж доктор Б.Тэмүүлэн бичсэнийг үгүйсгэх аргагүй¹⁴. Түүнчлэн Иргэний хуулийн 186.2-г илүүтэй хэрэглэгчийн

¹³ Hein Koetz, *European Contract Law*, 2nd edition, (Oxford University Press, 2017), 132-133.

¹⁴ Б.Тэмүүлэн, “Гэрээний стандарт нөхцөлийн гүйцэтгэх чиг үүрэг, агуулгын

гэрээнд хэрэглэх боломжтой. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд хэрэглэгчийн гэрээний тодорхойлолтыг өгч, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгайлсан зохицуулалтыг бүрдүүлсэн байна. Гэвч санхүүгийн хэрэглэгчийн эрхийн хамгаалалт олон улсын түвшинд хүрээгүй, бичил, жижиг бизнес эрхлэгчдийг гэрээний сул тал гэж үзэх нөхцөл, журмыг тогтоогоогүй байна.

В. Гэрээний эрх чөлөөг хүний суурь эрхээр хязгаарлах боломж

Европын зарим улсад гэрээний эрх зүйн хэрэглээг Үндсэн хуульд нийцүүлэх, хүний эрхийг хангахад чиглүүлж байна. Учир нь, улс орнуудын Үндсэн хууль болон НҮБ-ын санаачилсан Хүний эрхийн конвенциудад суурь эрхүүд(fundamental rights)-ийг баталгаажуулсан байдаг. Эдгээр эх сурвалж нь тухайн улсад дээд эрэмбийн эрх зүйн эх сурвалж болно.

Хувийн эрх зүй дэх үндсэн хуулийн нөлөөллийн асуудал орчин үеийн үндэсний эрх зүйн тогтолцоонуудын нэгэн нийтлэг зүйл болж байна. Үндсэн эрхийг гэрээний эрх зүйд харгалзан үзэх нь гэрээний эрх зүйг үндсэн хуульчлах үйл явц(constitutionalisation of contract law)-ын эхлэл болно. Үндсэн эрх нь улс ба иргэн/хувь этгээд хоорондын харилцаанд голлох нөлөөтэй байсан бол хувь этгээд хоорондын хувийн эрх зүйн харилцаанд үндсэн эрхийг хэрэглэх явдал ховор байв. Гэвч 1990-иад оноос эхлэн Европын зарим улсад гэрээний харилцаанд үндсэн эрх зөрчигдсөн бол тухайн гэрээг хүчингүйд тооцох практик гарч эхэлжээ. Жишээ нь, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх 1993 оны 10 дугаар сарын 19-ний өдөр шийдвэрлэсэн *Buergschaft* гэдэг кэйс.

Гэрээний эрх зүйд үндсэн эрхийг хамгаалахдаа “good fair and public policy” гэдэг үзэл баримтлалыг үндэслэж байна. ХБНГУ-ын олонд танигдсан *Buergschaft* гэдэг кэйст охин нь аавынхаа бизнесийн зээлийн талаар банкинд баталгаа/батлан даалт гаргасан ба ХБНГУ-ын Холбооны дээд шүүх үүнийг хүчин төгөлдөр баталгааны гэрээ гэж дүгнэсэн. Харин банк нэг талын журмаар охинд баталгаа гаргахыг охинд даалгасан уу, охинд санхүүгийн эрсдэлийн талаар мэдээлсэн үү гэдгийг Холбооны дээд шүүх шалгаагүй байна, улмаар Үндсэн хуулийн 2(1) дүгээр зүйлээр баталгаажсан охины өөрийгөө тодорхойлох (англ. right to self-determination – герм. Selbstbestimmung) эрх зөрчигдсөн байна гэж ХБНГУ-ын Холбооны Үндсэн хуулийн шүүхээс шийдвэрлэж хэргийг Холбооны дээд шүүх рүү буцаасан байна. Холбооны дээд шүүх дараахан нь Германы Иргэний кодексийн 138 дугаар зүйлд заасны дагуу зан суртахууны (good morals) хэм хэмжээг зөрчсөн учраас уг гэрээг хүчин төгөлдөр бус байна гэж 1994

онд шийдвэрлэжээ¹⁵.

Товч дүгнэхэд, ихэнх улс орнууд хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх, эх газрын эрх зүйн орнуудад гэрээний эрх чөлөөний үндсэн хуулийн хил хязгаарыг хүлээн зөвшөөрөх чиглэлд явж байна.

III. Олон улсын орчинд нийцүүлэх шаардлага

Өнөөдөр гэрээний багагүй хэсэг нь олон улсын шинжтэй буюу нэгээс олон улсад хамаарах агуулгатай байна. Гэрээний олон улсын шинжийг тодотгох цөөнгүй оролдлого хийгдсэн. Тухайлбал, ЮНИДРОУ-ын Олон улсын арилжааны гэрээний зарчмуудад “нэгээс олон улсад ихээхэн холбоотой”, “өөр улсуудын хуулийн хооронд сонголт хийхээр байгаа”, “олон улсын худалдааны сонирхолд нөлөө үзүүлэх” шинжийг заасан байдаг¹⁶. 1980 оны Венийн конвенцид “гэрээний талууд хоёр эсхүл түүнээс олон улсад бизнесийн холбогдох байршилтай” бол олон улсын гэрээнд хамаарахаар тодорхойлсон. Гаагийн бага хурлын зарчмууд¹⁷ болон Ром I зохицуулалтад¹⁸ ийм шууд тодорхойлолт байхгүй. Гэхдээ Ром I-ийн 3(3)-д үндэсний болон Европын холбооны хууль тогтоомжийг хэрэглэхээс татгалзахгүй байх нөхцлийг тусгасан нь нөгөө талдаа олон улсын гэрээг тодруулсан байдаг.

Гэрээний талууд тухайн гэрээнд хэрэглэгдэх хууль болон гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэх байгууллага, аргыг сонгох бүрэн боломжтой. Энэ нь гэрээний эрх чөлөөний нэг илрэх хэлбэр мөн.

A. Хэрэглэгдэх хуулийг сонгох боломж (choice of law clauses) ба хязгаарлалт (mandatory rules)

Гэрээний талууд гэрээнд хэрэглэх хууль болон шүүхийг сонгох (Choice-of-law clause and choice-of-forum clause) боломжтой. Хэрэв гэрээнд хэрэглэх хуулийг сонгоогүй бол эрх бүхий шүүх нь ОУХЭЗ-н журмыг баримтлан хэрэглэгдэх хуулийг тогтоох эсхүл олон улсын хэрэгслээр тодорхойлсон журам байвал түүнийг хэрэглэж болно.

Европын холбооны хувьд “Гэрээний үүрэгт хэрэглэгдэх хуулийн тухай зохицуулалт”(Rome I зохицуулалт)-ыг баталсан ба 2008 оны 8-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Rome I-ийн 3 дугаар зүйлд дээрх зарчмыг дэмжсэн агуулгатай заалтууд тусгагдсан байна. ЮНИДРОУ-ын Олон улсын арилжааны гэрээний зарчмууд ч

¹⁵ Bank guarantee case – en.wikipedia.org

¹⁶ <https://www.unidroit.org/contracts#UPICC>

¹⁷ <https://www.hcch.net>

¹⁸ <https://www.eur-lex.europa.eu>

мөн үүнийг дэмжсэн ба Гаагийн бага хурлын батлан гаргасан “Олон улсын арилжааны гэрээнд хууль сонгох зарчмууд” конвенцийн 12 дугаар зүйлд мөн л уг зарчмыг баталгаажуулсан байна.

Гэрээний талууд хууль зүйн тодорхой байдлыг хүсэж аль нэг улсын хуулийг хэрэглэхээр гэрээндээ тусгадаг. Тухайлбал, английн хуулийг далайн тээвэр, даатгал, чаптер тээвэрийн харилцаанд сонгодог бол Швейцарийн хуулийг төвийн сахисан гэдгээр сонгох тохиолдол бий. ИСС-ийн арбитрын статистик мэдээгээр аль улсын хуулийг илүүтэй сонгосныг мэдэж болох бөгөөд герман, францын хуулийг сонгох явдал түгээмэл байна.

Аль ч улсын хуулийг сонгосон, жишээ нь бараа худалдах худалдан авах олон улсын гэрээнд 1980 оны Венийн конвенц тухай улсын хуулийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болж хэрэглэгдэх магадлал өндөр. Венийн конвенцийн 6 дугаар зүйл дараах заалт тусгагдсан: “Талууд Конвенцийг хэрэглэхгүй байх, эсхүл аль нэг заалтыг хэрэглэхээс татгалзахаар тохиролцож болно”. Энэ заалт нь зөрчилдөөний болон материаллаг хэм хэмжээний аль альд нь хамаарч талуудын чөлөөт байдлыг хангасан байна. 1980 оны Венийн конвенцийг нэр зааж сонгох эсхүл огт нэрлэж сонгоогүй байх тохиолдлыг ялгаатай авч үзэх үү, үндэсний хуулийг нэрлэж сонгосон нь Конвенцийг хэрэглэхгүй байхаар тохиролцсон гэж ойлгох уу зэрэг асуулт тавигдаж болно. Эдгээр асуултад хариулахдаа талуудын хүсэл зориг болон олон улсын зохицуулалтын давуу байдлыг харгалзан үзэх нь зохистой.

Талуудын чөлөөт байдлын зарчмыг ихэнх улс хүлээн зөвшөөрч, өөрийн үндэсний хуульд тусгасан байдаг. Тухайлбал, хөрш БНХАУ, ОХУ-ын Иргэний хуулиас ийм заалтыг дэлгэрэнгүй зохицуулалт тайлбарын хамт олж болно.

Захирангуй хэм хэмжээ(Overriding mandatory rules) ба Нийтийн дэг журам (Public policy). Олон улсын арилжааны гэрээнд аль давамгай байдалтай тал нь өөрт илүү тааламжтай улсын хуулийг хэрэглэх хуулиар сонгох тохиолдол бий. Энэ нь аль нэг улсын үндэсний хуулийн зохицуулалтыг тойрох, өөрт илүү тодорхой, урьдчилан төсөөлөх боломжтой хуулиа сонгох зэрэг шалтгаантай байх нь элбэг. Нөгөө талаас зарим улс үндэсний хуулиар тогтоосон захирангуй буюу заавал дагаж мөрдөх шаардлагатай хэм хэмжээг, мөн өөрийн улсын нийтийн дэг журмыг сахиулах, мөрдүүлэх сонирхолтой байдаг. Энэ зөрчилтэй байдал өнөөгийн олон улсын арилжааны гэрээний зохицуулалтад тулгамдсан шинжтэй байна. Захирангуй хэм хэмжээ ба нийтийн дэг журмын талаарх дэлгэрэнгүй агуулгатай заалтуудыг Ром 1 Журамд тусгасан байна (Article 9. **Overriding mandatory provisions**, Article 21. **Public policy of the forum**).

Дүгнэлт. Талуудын чөлөөт байдлын зарчим бол гэрээний харилцаанд хамаарах олон улсын хувийн эрх зүйн суурь зарчим гэдгийг бүрэн хүлээн зөвшөөрсөн байна. Гэхдээ заавал мөрдөх журам ба нийтийн ашиг сонирхол гэх ойлголтыг хэрэглэх явдал хэвээр байна.

Б. Арбитрын хэлэлцээр ба шүүх сонгох гэрээ (Arbitration agreement and Agreements on Choice of Court)

Гэрээ байгуулах үед гэрээнээс үүссэн маргааныг аль улсын шүүхэд эсхүл ямар арбитрын байгууллагаар шийдвэрлүүлэхийг урьдчилан тохиролцож тогтоох нь стратегийн ач холбогдолтой. Арбитрын хэлэлцээрийн хувьд харьцангуй олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ба 1958 оны Нью Йоркийн конвенцоор арбитрын хэлэлцээр болон арбитрын шийдвэрийн хүлээн зөвшөөрч биелүүлэх асуудлыг зохицуулсан байна. Харин маргаан шийдвэрлэх шүүх сонгосон талуудын тохиролцоог зарим улсад хүлээн зөвшөөрөхгүй байх явдал цөөнгүй тохиолдоно.

Европын холбооны гишүүн улсуудад маргаан шийдвэрлэх шүүхийн талаар “Иргэний болон арилжааны хэргийг шийдвэрлэх шүүхийн харьяалал ба шүүхийн шийдвэрийн хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай Брюсселийн зохицуулалт” (Brussels I Regulation Brussels I bis)-г баталсан нь 2015 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс үйлчилж байна. Брюссел 1-д шүүхийн харьяалал, шүүхийг сонгох журмыг нарийвчлан зохицуулсан байдаг.

Гаагийн бага хурлаас “Шүүх сонгох гэрээний тухай” конвенц 2005 оны 6-р сарын 05-ны өдөр батлагдаж, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх шүүхээ сонгох боломжийг илүү тодорхой болгох оролдлого хийсэн.

В. Зөөлөн хуулийн өргөжилт

Сүүлийн үед заавал дагаж мөрдөх олон улсын гэрээний зэрэгцээ зөөлөн хуулийн эх сурвалж (soft laws) буюу загвар хууль, зарчим, ерөнхий нөхцөл, ижилтгэсэн баримт бичгүүдийг боловсруулан гаргахад илүү анхаарах болжээ. Энэ нь улсуудын үндэсний хууль тогтоомжийг ижилтгэхэд эерэг нөлөө үзүүлж байна. Үүний жишээ бол ЮНСИТРАЛ-аас 1985 онд батлан гаргасан Олон улсын худалдааны арбитрын тухай загвар хууль мөн. Данийн профессор Оле Ландо ахалсан Европын холбооны улсуудын эрдэмтдийн 1995-2002 онд боловсруулж бэлэн болгосон Европын гэрээний эрх зүйн зарчмууд (Principles of European Contract Law (PECL)) нь Европын нийтлэг гэрээний хууль бий болох эхлэл юм. Ийнхүү аль ч улс орны бизнес эрхлэгчдийн хувьд хүлээн зөвшөөрөхүйц гэрээний ижил төстэй суурь зарчмууд (common core) байгааг харьцуулсан эрх зүй судлаачид олон

жилийн өмнөөс судлан тогтоох оролдлого хийсээр байна¹⁹.

Олон улсын харилцаанд оролцогч бизнес эрхлэгч этгээд өөрийн сайн дурын үндсэн дээр сонгон хэрэглэх боломжтой эрх зүйн ижилтгэсэн хэм хэмжээ эсхүл хэв заншлыг агуулсан баримт бичиг боловсруулж, нийтэд түгээх арга өргөн дэлгэрч байна. ЮНИДРОИТ-ын Олон улсын арилжааны гэрээний зарчмууд (UNIDROIT Principles of International commercial contract - UPICC) бол ийм зөөлөн хуулийн нэг жишээ юм²⁰.

1919 онд байгуулагдсан Парисын Олон улсын худалдааны танхим (ICC –International Chamber of Commerce) олон улсын худалдааны ажил хэргийн заншлыг нэгтгэсэн баримт бичгүүд боловсруулан гаргаж нийтэд түгээх талаар амжилттай ажиллаж байна. Тухайлбал, ИНКОТЕРМС гэдэг баримт бичиг анх 1936 онд нийтлэгдсэнээс хойш бараа худалдааны гэрээний харилцаанд хамгийн түгээмэл хэрэглэгдэж иржээ.

Түлхүүр гардуулах нөхцлийн гэрээ (LSTK – Lump sum turn key), Инженер, худалдан авалт, барилгын гэрээ (EPC – Engineering, procurement, and construction) зэрэг томоохон иж бүрдэл бүхий дэд бүтэц, үйлдвэр, барилгын төслийн ажлыг гүйцэтгэх гэрээний үлгэрчилсэн загвар боловсруулж хөгжүүлдэг Зөвлөх инженерүүдийн олон улсын холбоо(FIDIC - International Federation of Consulting Engineers)байдаг²¹. Олон улсын төдийгүй үндэсний хэмжээнд тус холбооны боловсруулсан загварыг хэрэглэж гэрээ байгуулах практик өргөн дэлгэрч байна²².

Улсын шүүх аль нэг улсын хуулийг сонгож болохыг илүүтэй хүлээн зөвшөөрдөг бол арбитрын байгууллагууд зөвхөн улсын хууль бус, зөөлөн хуулийг хэрэглэхийг ч хүлээн зөвшөөрдөг. Ялангуяа ЮНИДРОУ-ын Олон улсын арилжааны гэрээний зарчмуудыг хэрэглэх 4 боломжийг уг зарчмуудад заасан байна. Гаагийн бага хурлаас баталсан Гаагийн зарчмуудад ч мөн ийм боломжийг дэмжсэн заалтыг оруулжээ. Гаагийн бага хурлын “Олон улсын гэрээнд хууль сонгох талаарх зарчмууд”-ын 3 дугаар зүйлд дараах заалт байна: (Article 3 Rules of law. The law chosen by the parties may be rules of law that are generally accepted on an international, supranational or regional level as a neutral and balanced set of rules, unless the law of the forum

¹⁹ С.Должин, “Харьцуулсан гэрээний эрх зүй”, Эрх зүй, 53 (3), 2016, 183 дахь тал.

²⁰ <https://www.unidroit.org/contracts#UPICC> - The UNIDROIT Principles of International Commercial Contracts (UPICC) constitute a non-binding codification or “restatement” of the general part of international contract law.

²¹ <https://fidic.org/>

²² Б.Батсэлэнгэ, Л.Отгонбаяр, А.Сэргэлэнтуяа болон бусад, Түлхүүр гардуулах нөхцөлтэй барилгын ажил гүйцэтгэх гэрээний хэрэглээ /ФИДИК гэрээний нөхцөлийн жишээн дээр/, (Улаанбаатар: 2002), 6-10 дахь тал.

provides otherwise.)

Зөөлөн хуулийг баримтлахыг дэмжих хандлага тод ажиглагдаж байхын зэрэгцээ практик ч дэлгэрч байна. Энэ нь талуудын чөлөөт байдлын зарчимтай шууд холбоотой. Үүнийг дагаж гэрээний харилцаанд үндэсний хуулийн оронд өөр зөөлөн хууль/хуулийн журмыг хэрэглэхээр талууд тохиролцох хандлага нэмэгдэж байна.

IV. Дижитал орчин ба гэрээний эрх зүйд тулгарч буй шинэ сорилт

Дижитал технологи нь олон улсын төдийгүй дотоодын эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаанд сайн нөлөө үзүүлэхийн зэрэгцээ зарим сорилтыг бий болгоно. Шинэ технологийн хамт хууль зүйн шинэ асуудал тулгарч байна. Үндэсний хуулиар бүх асуудлыг шийдэх боломжгүй ба олон улсын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой болж байна.

A. Дижитал зах зээл ба түүний сөрөг тал

Дижитал хөрөнгө, гэрээний харилцааны улмаас гэрээний шинэ төрөл үүсэж, үйлчилгээ, барааг хэрэглэх, худалдан авах арга хэлбэр шинэчлэгдэж байна. Онлайн платформыг шинээр үүсгэх, дижитал контентийг бүтээх, борлуулах арга ажиллагаа өргөжиж байна. Дундаа хамтран ашиглах, эзэмших хөрөнгийн нэр төрөл нэмэгдэж, share economy гэдэг өргөжих болжээ. Дижитал платформ нь зөвхөн зуучлах бус өөр олон үйлчилгээг үзүүлж, гэрээний харилцаанд гуравдагч этгээдийн өвөрмөц оролцоог бий болгоно. Uber-ийн үйлчилгээг энд жишээ болгож болно.

Европын комисс(European Commission)-оос “Дижитал нэгдмэл нэг зах зээл” (Digital single market)-ийн урт хугацааны төлөвлөгөө гаргаж, хэрэглэгч эсхүл бизнес эрхлэгч ялгаагүй нэгдмэл дижитал орон зайг бий болгох, дата чөлөөтэй нэвтрэх, шилжих боломжийг бүрдүүлэх, эрх зүйн орчныг тогтоох зорилго тавьж байна²³. Зайнаас гэрээ байгуулах, и-худалдаа хийх, цахим гарын үсэг ашиглах, санхүүгийн үйлчилгээг зайнаас үзүүлэх, дата мөнгө зэрэг олон практик нэвтэрч байна. Үүний хамт e-privacy, cybersecurity-г хангах сорилт тулгарна. Дижитал нийгэм: платформууд, онлайн зуучлагчид, үүлэн компьютерийн хэрэгсэл, data driving economy үүсэж, үүнийг дагасан уламжлалт болон ухаалаг гэрээний харилцааг зохицуулах өвөрмөц шаардлага тулгарч байна.

Дижитал хувьсгал нь гэрээний талуудын тэнцвэргүй байдлыг

²³ Directive (EU) 2019/790 of the European Parliament and of the Council of 17 April 2019 on copyright and related rights in the Digital Single Market and amending Directives 96/9/EC and 2001/29/EC - <https://eur-lex.europa.eu/eli/dir/2019/790/oj/eng>

нэмэгдүүлж байгаа бөгөөд гэрээний практикт өөрчлөлт оруулах, хуулийн зохицуулалтыг эргэж харах дараах шаардлагыг бий болгожээ. Үүнд:

Мэдээлэл ба ил тод бус байдал. Цахим орчинд худалдан авалт хийх, мэдээлэл олох, унших, түншээ сонгох зэрэг нь багагүй хугацаа шаардах ба хязгаарлагдмал цаг, харьцангуй тодорхой бус мэдээллийн хүрээнд сонголт хийх болдог. Түүнчлэн онлайн зуучлагчдын үйлчилгээний хөлс ил тод бус, зарим тохиолдолд их өндөр байгаа нь гүйлгээний зардлыг нэмэгдүүлэх нэг шалтгаан болно.

Стандарт гэрээний өсөлт. И-худалдаа эрчимжих тутам стандарт нөхцөл бүхий гэрээний тоо өснө. Хэдий ийм гэрээ нь талууд хэлэлцээр хийх цагийг багасгаж, гүйлгээний зардлыг багасгах сайн талтай ч ийм стандарт нөхцөлд уншихад бэрхшээлтэй, хууль зүйн түвэгтэй хэлээр бичигдсэн олон зүйл, заалт оруулах явдал бий. Практикт хэрэглэгч гэрээг унших тохиолдол маш бага байдаг. “Ав эсхүл орхи” (take it or leave it) гэдэг зарчмаар гэрээний нөхцлийг тулгаж байна. Тод жишээ бол, програм/software худалдах гэрээ. Ийм гэрээг онлайн зардаг ба хэрэгтэй бол бүх нөхцлийг зөвшөөрөхөөс өөр аргагүй. Сүүлийн үед зөвхөн B2C хэрэглэгчийн гэрээ гэхгүйгээр B2B арилжааны гэрээний хувьд ч шударга бус нөхцлийг хянах асуудал бол гэрээний эрх зүйд их анхаарал татах болов.

Гэрээ хоорондын хамаарлын өсөлт. Гэрээний харилцаанд оролцогчдын эрх үүрэг өөр гэрээний харилцаанаас хамаарах явдал улам өргөжиж байна. Жишээ нь, барилгын ажил гүйцэтгэх гэрээний ерөнхий гүйцэтгэгч, түүний туслан гүйцэтгэгч, мөн түүний туслан гүйцэтгэгч г.м. гинжин хэлхээ үргэжилнэ. Нэг туслан гүйцэтгэгч үүргээ биелэгдээгүйн улмаас бусад гүйцэтгэгч нар, улмаар захиалагч ч мөн бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрнэ. Дижитал ертөнцөд олон оролцогчидтой гэрээ, гэрээтэй төстэй харилцаа түгээмэл тохиолдоно. Үүнийг хуулиар зохицуулах шаардлага, боломж байна уу, зохицуулбал хэрхэн зохицуулах уу гэдэг асуулт тавигдаж байна.

Б. Гэрээний шинэ дүрс, хамтын хариуцлага

Ухаалаг гэрээнүүд (Smart contracts). Автоматаар гэрээ байгуулагдах нь уламжлалт санал, хариу өгөх замаар гэрээ байгуулахаас ялгаатай. Ухаалаг гэрээ нь уламжлалт гэрээний ойлголтод хамаарахгүй, програмчлагдсан үйлдэл-хариу үйлдэл-үр дагаврын хэлхээг илэрхийлнэ. Компьютерийн протокол нь гэрээг бий болгож, гэрээний нөхцлийг шалгаж эсхүл албадан гүйцэтгэх ажиллагааг хариуцах бөгөөд ийм гэрээг компьютерын мэргэжилтнүүд “smart contract” гэж нэрлэдэг. Ethereum blockchain platform бол нилээд

алдартай ухаалаг гэрээний хэрэгжилт мөн. Өөрчлөх боломжгүй, үл маргах, үл уучлах хатуу нөхцөлтэй алгоритмын дагуу үүсэж хэрэгжих ухаалаг гэрээ нь цаашид хууль зүйн томоохон нэг сорилт болж байна.

Ялангуяа харилцаа холбоо, цахилгаан, дулаан, ус хангамжийн зэрэг олон нийтийн шинжтэй гэрээний харилцаанд ухаалаг гэрээний шинж бүхий аргачлалыг өргөнөөр ашиглаж эхэлснийг өнөөдөр бид өөрсдийн амьдралд мэдэрч байна. Мөнгө төлнө - дата багц авна, багц дуусна хэрэглээ хаагдана. Ийм жишээ олон болсон ба цаашид ч нэмэгдэхээр байна. Шинэ шинэ апп гарч, төрөл бүрийн үйлчилгээг санал болгоно, улмаар олон иргэдээс төлбөр авчихаад чанаргүй үйлчилгээ үзүүлэх, хуурч мэхлэх, эзэн холбогдогч олдохгүй байх магадлал, эрсдэл дагаж өснө.

Эд юмсын интернэт (internet of things) дэх хамтын(shared) хариуцлага. Өөрөө явдаг автомашин, роботууд, ухаалаг үйлдвэрийн газрууд, гэрийн ухаалаг хэрэгсэл зэрэг эд юмсын орон зайд хүссэнээрээ саадгүй аялах, тэдгээрийг чөлөөтэй хэрэглэх явдал бодит зүйл болж байна. Ийм орон зайд гэрээний болон гэрээний бус хариуцлагыг хэн яаж хүлээх вэ гэдэг хууль зүйн асуулт тавигдана. Нэг оролцогч бусад оролцогчдоос хамтын хариуцлагыг шаардаж болох уу. Жишээ нь, Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын гудамжинд интернэт, тусгай апп, орон зайн мэдрэгчийн тусламжтай ажилладаг түрээсийн скүүтер, мопед, цахилгаан дугуй их хэмжээгээр үзэгдэж, тэдгээрийн хэрэглээ ч огцом өсөж байна.

В. Гэрээний харилцаан дахь хиймэл оюун ухаан (AI)

Хэлэлцээр явуулах, хууль зүйн магадлан шалгалт хийх, гэрээний төсөл бэлтгэх, гэрээ байгуулах, гүйцэтгэх, гүйцэтгэлд хяналт тавих, үүргийг албадан гүйцэтгүүлэх зэрэг бүхий л ажиллагаанд хуульчийн төдийгүй, шүүх, хууль сахиулах байгууллагын чиг үүрэг, оролцоог хиймэл оюун орлох үйл явц эрчимтэй өрнөж байна. Гэрээ төдийгүй хууль тогтоомжийн төслийг бэлтгэх, сайжруулах, хүчин төгөлдөр хуулийн хэрэгжилт, үр нөлөөд хяналт шинжилгээ хийх ажиллагаанд ч хиймэл оюун ухааныг ашиглах хэвийн зүйл боллоо. Түүнчлэн зарим төрлийн маргааныг шийдвэрлэх, шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажиллагааг хиймэл оюун ухаан илүү шуурхай, хөндлөнгийн хараат бус байдлаар явуулах нөхцлийг хангах боломжтой.

Гэрээний эрх чөлөөний хүрээнд талууд гэрээний төслөө бэлтгэх, байгуулах, албажуулах ажиллагаанд хиймэл оюун ухаан ашиглах нь чөлөөтэй, хүлээн зөвшөөрөгдөнө. Түүнчлэн гэрээний хэрэгжилт болон гэрээнээс үүссэн маргааныг шүүх, арбитраар бус, хиймэл оюун ухаанаар үнэлүүлж, шийдвэр гаргуулахаар талууд тохиролцох бүрэн боломжтой. Ойрын үед хиймэл оюун ухаанд түшиглэсэн маргаан

шийдвэрлэх эсхүл шүүхийн шийдвэрийг урьдчилан таамаглах үйлчилгээ үүсэх техникийн нөхцөл бүрдэх боломжтой болжээ²⁴. Харин ийм үйлчилгээг хүлээн зөвшөөрсөн, түүнчлэн хиймэл оюун ухааны гаргасан шийдвэрийг шүүхийн журмаар албадан гүйцэтгүүлэх эрх зүйн орчин өнөөгийн байдлаар манай улсад бүрдээгүй байна. Цаашид гэрээний талууд хиймэл оюун ухааны маргаан шийдвэрлэх эсхүл маргааны үр дүнг таамаглах үйлчилгээг авахаар тохиролцох боломжийг хуулиар зохицуулах шаардлага үүсэж байна.

V. Дүгнэлт:

Үндэсний эрх зүйн тогтолцоонууд аажмаар ойртон ижилсэж байна.

Улс орнууд нийгэм, улс төр, эдийн засгийн орчны өөрчлөлт, технологийн дэвшилийг харгалзан эрх зүйн шинэтгэл хийж, бизнес эрхлэх орчноо тааламжтай, өрсөлдөхүйц болгохыг зорьж байна. Энэ хүрээнд олон улсын сайн туршлага, бусад улсын хууль тогтоомжийн шинэтгэлийг харгалзан үзэх замаар үндэсний хууль тогтоомжоо шинэтгэх арга хэмжээг авдаг. Түүнчлэн улс оруудын судлаачдын хамтын ажиллагаа, харилцан мэдээлэл солилцоо, харьцуулсан судлал эрчимтэй өргөжиж байна. Ийм шалтгаанаар улс орнуудын эрх зүй, тэр дундаа гэрээний эрх зүйн хууль тогтоомжийн зохицуулалт харилцан уусах, ижил үзэл баримтлалд үндэслэх явдал аажмаар нэмэгдэж байна. Монгол Улс энэ үйл явцаас хоцорч болохгүй.

Олон улсын хэмжээнд гэрээний эрх зүйн зохицуулалтыг ижилтгэх, нэгдмэл эх сурвалж бий болгох оролдлого амжилттай явагдаж байна.

Энэ чиглэлд олон улсын байгууллагууд идэвхитэй хамтран ажиллаж байна. Талуудын чөлөөт байдлын зарчим бол гэрээний харилцаанд хамаарах олон улсын хувийн эрх зүйн суурь зарчим гэдгийг бүрэн хүлээн зөвшөөрч, гадаад улсын хууль хэрэглэн гадаад улсын шүүх, арбитраар маргаан шийдвэрлэх явдал хэвийн үзэгдэл болов. Манай улс ЮНИДРОУ болон Гаагийн Бага хурлын гишүүн улс болж, үйл ажилагаанд нь оролцох боломж нээгдсэн бөгөөд цаашид идэвхитэй хамтран ажиллах шаардлага тулгарч байна.

Нэгдмэл эх сурвалжийн зэрэгцээ зөөлөн хуулийг өргөжүүлэхэд илүү анхаарах болжээ.

Гэрээний харилцаанд үндэсний хуулийн оронд өөр зөөлөн хууль/хуулийн журмыг хэрэглэхээр тохиролцох хандлага нэмэгдэж байна. Харин үндэсний хуулиар тогтоосон захирангуй хэм хэмжээ

²⁴ Ричард Саскинд, Цахим шүүх ба шүүх эрх мэдлийн ирээдүй, (Орч. Сэрээнэнгийн Цэрэндолгор), (Улаанбаатар: Оксфорд хэвлэл, 2025), 327-330 дахь тал.

(mandatory rules), нийтийн дэг журам(ordre public)-ын асуудал өнөөгийн олон улсын арилжааны гэрээний зохицуулалтад тулгамдсан шинжтэй байна. Энэ чиглэлд нийцэхийн тулд манай улс иргэний хууль тогтоомж дахь хэм хэмжээний зөвшмөл ба захирангуй шинжийг илүү тодорхой, ойлгомжтой болгох нь зохистой.

Дижитал орчинд дасан зохицох үйл явц үргэлжилж байна.

Улс орон бүрийн шүүх, арбитр дижитал орчинд нийцсэн хууль хэрэглээний бодлогыг баримталж, гэрээний хэлбэрийн шаардлага, нотлох баримтын үнэлгээнд уян хатан хандаж байна. Хуульчдын хувьд даяаршсан цахим орчинд гэрээ хэлэлцээр хийх, хууран мэхлэлт, маргаанаас зайлхийхэд зөвлөгөө өгөх, өөрийн үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан ашиглах шинэ сорилт тулгарч байна. Эхний ээлжинд манай улс дижитал орчинд дасан зохицсон хууль хэрэглээний практикыг дэмжсэн бодлого баримтлах нь үр дүнтэй.

[Ном зүй]

Л.Банзрагч “Санхүүгийн хэрэглэгчийн хувийн эрх зүйн хамгаалалтын өнөөгийн байдал – Хэрэглэгчийн зээлийн гэрээний хүрээнд”, Хэрэглэгчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, харьцуулсан судалгаа, Эмхэтгэсэн Р.Пүрэвбаатар, Улаанбаатар, 2022 он.

Б.Батсэлэнгэ, Л.Отгонбаяр, А.Сэргэлэнтуяа болон бусад, Түлхүүр гардуулах нөхцөлтэй барилгын ажил гүйцэтгэх гэрээний хэрэглээ / ФИДИК гэрээний нөхцөлийн жишээн дээр/, Улаанбаатар, 2002 он.

Бат-Эрдэнийн Буянхишиг Монгол Улсын хувийн эрх зүйн үндсэн кодификац, харьцуулалт, Улаанбаатар, 2021 он.

Т.Дайчин “БНХАУ-ын Иргэний хуулийн хөгжлийн үе шат (Иргэний хуулийн бичиг боловсруулалтын хүрээнд)”, Эрх зүй, 52 (2), 2016 он.

С.Должин “Харьцуулсан гэрээний эрх зүй”, Эрх зүй, 53 (3), 2016 он.

Т.Мөнхжаргал Иргэний эрх зүй: Ерөнхий анги, Улаанбаатар, 2003 он.

Түмэнжаргалын Мэндсайхан Гэрээний эрх зүй, Улаанбаатар, 2021 он.

Түмэнжаргалын Мэндсайхан “Орон сууцны талбайн маргаан бүхий иргэний хэрэг ба Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн хэрэглээ (Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ)”, Эрх зүй, 51 (1), 2019 он.

Түмэнжаргалын Мэндсайхан “Хууль зүйн техник ба холбоос үгийн хэрэглээ”, Хууль дээдлэх ёс, 76 (2), 2022 он.

Жаргалсайханы Оюунтунгалаг Иргэний эрх зүй: Ерөнхий анги, Улаанбаатар, 2020 он.

Жаргалсайханы Оюунтунгалаг Худалдах худалдан авах гэрээний онцлог, Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэх гэрээ ба Иргэний хуулийн хэрэглээ: сургалтын гарын авлага, Улаанбаатар, 2017 он.

Жаргалсайханы Оюунтунгалаг Иргэний эрх зүй: Гэрээний үүрэг, Улаанбаатар, 2022 он.

Ричард Саскинд, Цахим шүүх ба шүүх эрх мэдлийн ирээдүй, (Орч. С.Цэрэндолгор), Улаанбаатар: Оксфорд хэвлэл, 2025 он.

Б.Тэмүүлэн “Гэрээний стандарт нөхцөлийн гүйцэтгэх чиг үүрэг, агуулгын хяналт”, Эрх зүй, 52 (2), 2016 он.

Beale H., Fauvarque-Cosson B., Rutgers J., Vogenauer S., Cases, Materials and Text on Contract Law, 3rd Edition, Oxford: Hart Publishing, 2019.

Chen-Wishart M., Contract Law, 7th edition, Oxford: Oxford University Press, 2022.

Koetz H., European contract law, 2nd edition, Oxford: Oxford University Press, 2017.

Monateri P. G. (Ed.), Comparative Contract Law, Cheltenham: Edward Elgar Publishing, 2018.

Moore M., “Developments in Contract Law: The 2021-2022 Term — The Enduring Allure of Freedom of Contract”, Sup Ct L Rev (2d), 111, 2023.

Rowan S., The New French Law of Contract, Oxford: Oxford University

Press, 2017.

<https://fidic.org/> - ФИДИК-ийн гэрээний нөхцөлүүд.

<https://www.hcch.net>.

<https://www.unidroit.org/contracts#UICC> - The UNIDROIT Principles of International Commercial Contracts (UICC).

<https://eur-lex.europa.eu/eli/dir/2019/790/oj /eng> - Directive (EU) 2019/790 on copyright and related rights.

https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/19-09951_e_ebook.pdf - Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц.

[Abstract]

Common Trends in Contract Law Development

Mendsaikhan Tumenjargal

Doctor of Laws (Ph.D).

Associate Professor at the Private Law Department

School of Law, National University of Mongolia

Ulaanbaatar, Mongolia

In recent years, the need to regularly update national legislation, including contract law, has become essential to keep pace with technological revolutions, shifts in social values, trends in commercial practices, international best practices, and legal changes in other countries. Legal developments related to contract predictability, the need to address disadvantages, effective methods of contractual liability, the impact of fundamental rights, and the choice of sources have significantly influenced legislative reforms as well as judicial and arbitral practices across many nations. Additionally, the growth of cross-border contractual relations, rules on the choice of law and jurisdiction in international contracts, and the rise of digital contracts continue to attract international attention. In this context, this article aims to identify the overall trends in the development of contract law and to propose solutions for some issues affecting Mongolia's contractual relations.

[Keywords]

Modern Contract Law, Predictability of Contracts, Weaker Party of Contract, Statutory Interest, Fundamental Human Rights, Choice of Applicable Law, Arbitration Agreement, Choice of Court, Soft Law, Digital Contracts.